



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО



ᠮᠤᠩᠭᠡᠯᠤᠯᠤᠰ  
ᠰᠠᠨᠬᠡᠭᠢᠢᠨ  
ᠵᠣᠬᠢᠴᠢᠭᠤᠯᠠᠬᠤ  
ᠬᠣᠷᠤᠨ

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН 2019 ОН





# АГУУЛГА

---

<b>НЭГ.</b>	<b>МЭНДЧИЛГЭЭ</b>	<b>4</b>
<b>ХОЁР.</b>	<b>ОН ЦАГИЙН ТОВЧООН</b>	<b>6</b>
<b>ГУРАВ.</b>	<b>ХУРААНГУЙ</b>	<b>8</b>
<b>ДӨРӨВ.</b>	<b>САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА</b>	<b>9</b>
<b>ТАВ.</b>	<b>САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН</b>	<b>10</b>
<b>ЗУРГАА.</b>	<b>ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>	<b>11</b>
<b>ДОЛОО.</b>	<b>ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ</b>	<b>12</b>
<b>НАЙМ.</b>	<b>САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ</b>	<b>13</b>
<b>ЕС.</b>	<b>БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	<b>14</b>
<b>АРАВ.</b>	<b>БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	<b>24</b>
<b>АРВАН НЭГ.</b>	<b>ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	<b>26</b>
<b>АРВАН ХОЁР.</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	<b>29</b>
<b>АРВАН ГУРАВ.</b>	<b>МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	<b>30</b>
<b>АРВАН ДӨРӨВ.</b>	<b>ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА</b>	<b>35</b>
<b>АРВАН ТАВ.</b>	<b>СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ</b>	<b>38</b>
<b>АРВАН ЗУРГАА.</b>	<b>ТӨСӨВ, САНХҮҮ</b>	<b>39</b>
<b>АРВАН ДОЛОО.</b>	<b>ОЛОЛТ, АМЖИЛТ</b>	<b>40</b>

# ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

---

- Зураг 1.** Санхүүгийн зохицуулах хорооны бүтэц, зохион байгуулалт
  - Зураг 2.** Санхүүгийн зохицуулах хорооны албан хаагчдын мэдээлэл
  - Зураг 3.** Санхүүгийн салбарын онцлох үзүүлэлтүүд
  - Зураг 4.** Санхүүгийн салбарын статистик үзүүлэлтүүд
  - Зураг 5.** Үнэт цаасны салбарын бүртгэл, зөвшөөрлийн мэдээлэл
  - Зураг 6.** Банк бус санхүүгийн байгууллагын салбарын бүртгэл, зөвшөөрлийн мэдээлэл
  - Зураг 7.** Зайны хяналт, шалгалтын мэдээлэл
  - Зураг 8.** МУТСТ чиглэлээр гүйцэтгэсэн газар дээрх хяналт, шалгалт
  - Зураг 9.** Газар дээрх хяналт, шалгалтын мэдээлэл, салбарын оролцогчдоор
  - Зураг 10.** Улсын байцаагчийн албан шаардлагын мэдээлэл
  - Зураг 11.** Өргөдөл, гомдол, тэдгээрийн шийдвэрлэлтийн мэдээлэл
- 
- Хүснэгт 1.** Дээд газрын тогтоол, шийдвэрийн биелэлт
  - Хүснэгт 2.** 2019 онд бүртгэгдсэн захиргааны хэм, хэмжээний актууд
  - Хүснэгт 3.** Банк бус санхүүгийн байгууллагын салбарын бүртгэл, зөвшөөрлийн мэдээлэл, зөвшөөрлийн төрлөөр
  - Хүснэгт 4.** Төсөв, санхүүгийн мэдээлэл

# ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

---

АНДББ	Ази номхон далайн бүсийн бүлэг
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АХБ	Азийн хөгжлийн банк
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
МББСБХ	Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо
МУТС	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх
МУТСТ	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
МУЦАЭХ	Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо
МХЗХҮХ	Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо
ОУВС	Олон улсын валютын сан
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
УБАШ	Улсын байцаагчийн албан шаардлага
УИХ	Улсын Их Хурал
ҮЦК	Үнэт цаасны компани
ХАА	Хөдөө аж ахуй
ХААБ	Хөдөө аж ахуйн бирж
ХЖДХ	Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү
ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХОМК	Хөрөнгө оруулалтын менежментийн компани
ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ФАТФ	Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага



## ■ МЭНДЧИЛГЭЭ



Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны үйл ажиллагааны тайланг Танд өргөн барьж байна.

2019 онд санхүүгийн зохицуулагч байгууллага үүсэж хөгжсөний 25 жил, Монгол Улсад арилжааны даатгалын тогтолцоо бий болсны 85 жилийн ой тохиож хийсэн ажил, ололт амжилтаа эргэн харж, өнгөрснөө дүгнэн, цаашдын хэтийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээгээ тодруулж, хөгжлийн төлөө тэмүүлсэн урам зоригоор дүүрэн оноо үдлээ.

Тайлант онд санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх үндсэн бодлогын баримт бичиг болох “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”, “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги, төлөвлөгөө 2018–2021”-ийн хүрээнд тавьсан зорилтуудаа хэрэгжүүлэхэд голлон анхаарч ажиллалаа. 2019 онд банкнаас бусад санхүүгийн зах зээл өмнөх

оноос 15.8 хувиар өсөж, ДНБ–д эзлэх хувь 13.6–д хүрлээ.

Тус онд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлын хүрээнд журам, зааврууддаа ФАТФ–ын стандартад нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт хийж, Олон улсын валютын сангийн эрсдэлийг үнэлэх аргачлалыг ашиглаж банкнаас бусад санхүүгийн зах зээлд үнэлгээ хийн, эрсдэл өндөртэй санхүүгийн байгууллагуудад газар дээрх хяналт шалгалтыг гүйцэтгэж тодорхой үр дүнд хүрээд байна. Түүнчлэн олон нийтийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэх, санхүүгийн дэвшилтэт технологийг дэлгэрүүлэхэд зах зээлд оролцогчдыг дэмжихэд онцгойлон анхаарч ажиллаж байна.

СЗХ нь банкнаас бусад санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, зохицуулалтын арга барилыг сайжруулах, олон улсын стандартыг нэвтрүүлэх зорилгоор олон улсын санхүүгийн зохицуулагч байгууллагууд болох Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI), Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO) болон Даатгалын хяналт шалгалтын олон улсын байгууллага (IAIS)–тай хамтран ажиллаж байгаагийн зэрэгцээ ЖАЙКА, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банк, Дэлхийн банкны төслүүдийг хэрэгжүүлж байна.

2020 онд бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, санхүүгийн дэвшилтэт технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход гол анхаарлаа хандуулах бөгөөд холбогдох хуулиудыг УИХ–д хүргүүлэх болно.

Мөн шинээр зохицуулалтад орж буй үл хөдлөх

## ■ МЭНДЧИЛГЭЭ

эд хөрөнгө зуучлалын болон үнэт металл, үнэт эдлэлийн, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарын үйл ажиллагаа явуулах хууль, эрх зүйн орчныг бий болгох, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх ажиллагааг эхлүүлж, тэдгээрт тавих хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэхэд онцгойлон анхаарч ажиллах жил болно.

Бидний 2020 онд тавьсан гол зорилтын нэг бол Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улсуудын ажиглалтын "саарал" жагсаалтаас гаргах, 2020 онд уг үнэлгээг бүрэн хангахад чиглэгдсэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх болно.

2020 онд санхүүгийн тогтвортой байдлыг хангахад нэгдсэн бодлогын хүрээнд салбарын

бодлогын зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, системийн эрсдэлийн удирдлага болон хямралын үеийн тогтолцоог нэвтрүүлж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг бүрэн хэрэгжүүлэхээс гадна зохицуулалттай этгээдүүдийн компанийн засаглалыг сайжруулан, комплайнсын тогтолцоотой болгох, олон нийтийн санхүүгийн боловсролыг тууштай дээшлүүлэхэд зорин ажиллана.

2020 онд санхүүгийн зах зээлийг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх, харилцагч, хөрөнгө оруулагч, даатгуулагчдын итгэлийг хүлээсэн санхүүгийн үйлчилгээг хялбар, шуурхай хүргэхэд хамтран ажилладаг Төрийн бодлого тодорхойлогчид, Мэргэжлийн холбоод болон зохицуулалтын байгууллагууд Та бидний хамтын ажиллагаа амжилт, үр бүтээлээр дүүрэн байна гэдэгт итгэлтэй байна.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА



Д.БАЯРСАЙХАН



## ОН ЦАГИЙН ТОВЧООН



### Нэгдүгээр сар

"Хүртээмжтэй санхүү" сэтгүүлийг эрхлэн гаргаж эхлэв.

### Гуравдугаар сар

"Эрдэнэс Тавантолгой" компани хаалттай хувьцаат компани болов.



"Даатгалын багц дүрэм"-ийг Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэв.

### Дөрөвдүгээр сар

Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг бууруулж шинэчлэн тогтоов.

ЖАЙКА-тай хамтран хэрэгжүүлэх "Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх-II" төсөл хэрэгжиж эхлэв.

### Тавдугаар сар

АХБ-тай хамтран хэрэгжүүлж буй "Бичил санхүүгийн байгууллагыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл"-ийн II шат хэрэгжиж эхлэв.



"Санхүүгийн салбарын комплайнс хэлэлцүүлэг 2019" зохион байгуулагдав.



### Наймдугаар сар

Говь-Алтай болон Ховд аймагт "Санхүүгийн зах зээл" нээлттэй өдөрлөгийг зохион байгуулав.



### Долоодугаар сар

Онцгой нөхцөл байдал үүссэн ҮЦК-ийн харилцагчдыг өөр зохицуулалттай этгээдэд шилжүүлэв.



### Зургаадугаар сар

Гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай анхны хөрөнгө оруулалтын менежментийн компани үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхлэхээр болов.



**Есдүгээр сар**

“Санхүүгийн зах зээлийн нээлттэй өдөрлөг”-ийг Дархан–Уул аймагт зохион байгуулав.



**Аравдугаар сар**

Улсын Их Хурлаас 2019 оны 10 дугаар сарын 18–ны өдөр шинэчлэн баталсан Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд өмнө нь зохицуулалтгүй байсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа”, “Үл хөдлөх эд хөрөнгө, зуучлалын байгууллагын үйл ажиллагаа”-г СЗХ шинээр хянаж, зохицуулахаар болов.

СЗХ–ны даргаар Д.Баярсайхан томилогдож, тамгаа гардан авав.



**THE WORLD BANK**

**Арваннэгдүгээр сар**

Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд МУТС–тэй тэмцэх тогтолцоог сайжруулах, Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага (FATF)–ын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтарч ажиллахаар болов.



Санхүүгийн зохицуулагч байгууллага үүсгэн байгуулагдсаны 25 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулав.

**Арванхоёрдугаар сар**

Олон улсын санхүүгийн корпораци (IFC)–тай хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар санал солилцож, ялангуяа Монгол Улсын бүс нутагт болон хилийн чанадад үндэсний мөнгөн тэмдэгтээр бонд босгох, ногоон санхүүжилтийг хөгжүүлэх, түүнийг банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаатай уялдуулах талаар хамтран ажиллахаар тохиролцов.

## ХУРААНГУЙ

Худалдааны дайн, эдийн засгийн тодорхойгүй байдлын улмаас 2019 онд дэлхийн эдийн засаг таамагласнаас 0.3 хувиар буурч 3.0 хувьд хүрэв. Монгол Улсын эдийн засаг 2019 онд сэргэж бодит ДНБ 36.9 их наяд төгрөгт хүрч 5.1 хувиар өсөв. Гадаад худалдааны хувьд экспорт 7.6 сая ам.доллар, импорт 6.1 сая ам.долларт хүрч нийт тэнцэл 1.5 сая ам.доллар гарч өмнөх оноос 31.3 хувиар сайжирлаа. Манай улсын аж үйлдвэрийн салбарын 63 хувийг уул уурхай, 26 хувийг боловсруулах үйлдвэр, 11 хувийг цахилгаан, дулаан, эрчим хүч үйлдвэрлэлийн салбар зонхилон эзэлж байна. Уул уурхайн бараа бүтээгдэхүүн, түүний экспортоос өндөр хамааралтай манай орны хувьд уул уурхайн гаралтай бараа, түүхий эдийн үнээс шалтгаалан эдийн засгийн өсөлт саарах улмаар зээлийн чанарт нөлөөлөх, хөрөнгийн зах зээл дээрх хувьцааны үнэд ихээхэн нөлөө үзүүлдэг. Иймд санхүүгийн зах зээл нь эдийн засаг, тэр дундаа уул уурхайн салбараас өндөр хамааралтай. Тайлант онд гадаадын 2,899.9 сая ам.долларын шууд хөрөнгө оруулалт орж ирсэн нь өмнөх хоёр жилээс өссөн дүнтэй байна.

Үнэт цаасны зах зээлд 2019 онд нийт 526 байгууллага зохицуулалттайгаар үйл ажиллагаа эрхэлж, данс эзэмшигчдийн тоо 1.8 саяд хүрлээ. Нийт үнэт цаасны арилжаа 41.5 хувиар буурсан бөгөөд энэ нь нэр бүхий ХК-уудын багцын арилжааны дүн 2018 онд өндөр байсантай холбоотой. Харин зах зээлийн үнэлгээ 2.7 их наяд төгрөгт хүрч 7.2 хувиар өссөн бол ТОП-20 индекс 1,844.9 нэгжээр буурч 19,621.9-д хүрсэн байна.

ХАА-н бараа, таваарын зах зээлийн хувьд тайлант онд 705.1 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оноос 6.4 тэрбум төгрөгөөр буурчээ. ХААБ-ийн МАPIX индекс 794,316.1 нэгжид хүрч өмнөх оноос 67,104.4 нэгжээр доошлов.

Даатгалын салбарт нийт 317 даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч, аудитын компани, актуарч, аудитор, 2,520 даатгалын төлөөлөгч 1,153,392 даатгуулагчдад бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хүргэн ажиллажээ. Даатгалын салбарын нийт хөрөнгө 365.8 тэрбум төгрөгт хүрснээс 45.3 хувь буюу 165.6 тэрбум төгрөгийг нөөц сан зээлж байна.

Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд 2019 онд нийт 196.6 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлжээ. Нийт 57.3 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжид зарцуулсны 2.1 тэрбум төгрөг буюу 3.7 хувийг дотоодын давхар даатгагчид төлсөн байна. Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 2019 онд 65.5 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 12.5 хувиар өсчээ.

Тайлант онд 538 ББСБ үйл ажиллагаа явуулж, салбарын харилцагч болон зээлдэгчдийн тоо 1.8 дахин нэмэгдэж тус бүр 2.9 сая, 419.9 мянгад хүрсэн нь санхүүгийн технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ уг салбарт нэвтэрсэнтэй холбоотой огцом өсөлтийг үзүүлжээ. Нийт хөрөнгө 1.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 34.7 хувиар өсөв. Үүний 1.2 их наяд төгрөгийг зээл хэлбэрээр санхүүжилтэд олгосны 87 хувь нь хэвийн ангилалд байна.

ХЗХ-дын тоо өмнөх оноос 6.5 хувиар буурч 261 болж, гишүүдийн тоо 13.4 хувиар өсөж 70,968-д хүрлээ. Тайлант онд ХЗХ-дын нийт хөрөнгө өмнөх оноос 11.2 хувиар өсөж 222.6 тэрбум төгрөгт хүрчээ.

8 Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160

📞 976 51 264444

✉ [press@frc.mn](mailto:press@frc.mn)

🌐 [www.frc.mn](http://www.frc.mn)

📍 Санхүүгийн зохицуулах хороо

📍 @FRC\_of\_Mongolia



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА

Санхүүгийн зохицуулах хороо нь 2006 онд УИХ-аас Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийг баталснаар 1994 онд байгуулагдаж байсан Үнэт цаасны хорооны суурин дээр даатгал, бичил санхүүгийн салбарын зохицуулалт нэмэгдэн банкнаас бусад санхүүгийн зах зээлийг зохицуулахаар үйл ажиллагаагаа эхлүүлсэн түүхтэй.

СЗХ нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагч, харилцагч, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, банкнаас бусад санхүүгийн зах

зээлд хяналт шалгалт хийх, бодлого, зохицуулалтын орчныг бүрдүүлэх чиг үүрэгтэй.

2019 он СЗХ-ны хувьд санхүүгийн зохицуулагч байгууллага үүсгэн байгуулагдсаны 25 жилийн тэмдэглэлт ой тохиосон ба тус онд нийт 124 албан хаагчтайгаар 4 салбарын 2,433 зохицуулалттай этгээдэд хяналт, шалгалт хийж, бодлогын арга хэмжээ авч ажиллалаа.


### АЛСЫН ХАРАА

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт, тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож, эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.

### ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж, олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

### ҮНЭТ ЗҮЙЛС



### САЛБАРЫН БҮРЭЛДЭХҮҮН








## ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Зураг 3. Санхүүгийн салбарын онцлох үзүүлэлтүүд



## ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Технологийн дэвшил ба шинэ санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ: 2019 онд финтекийн чиглэлээр гар утсанд суурилсан бодит цагийн горимоор төлбөр тооцоог хийх бүтээгдэхүүн болон үүлэн технологид суурилсан үйлчилгээ эрчимтэй нэвтэрсэн. Өөр нэгэн хурдтай тархаж буй шинэ технологийн хандлага нь санхүүгийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэх квантум технологи юм.

- ОУВС–ын тооцоолсноор дэлхийн эдийн засаг 2019 онд таамагласнаас 0.3 хувиар буурч 3 хувьд хүрэв.
- АНУ болон Хятад улс хоорондын худалдааны дайн, Их Британи улс Европын холбооноос гарахад үүссэн тодорхой бус байдал эдийн засгийн бууралтад нөлөөлсөн.

Бичил санхүүгийн салбар: Сүүлийн 10 жилд бичил санхүүгийн салбараас санхүүжилт авсан зээлдэгчдийн тоо 43 хувиар өссөн ба нийт 139.9 сая зээлдэгчдийн 80 хувь нь эмэгтэй, 65 хувь нь хөдөө, орон нутгийн иргэд байна.



Өмнөд Азийн улсууд болох Энэтхэг, Бангладеш, Вьетнам зэрэг улсууд бичил санхүүгийн салбарын үйлчилгээгээр тэргүүлсээр байна.

Хөрөнгийн зах зээлийн үзүүлэлтүүд 2008 оны санхүүгийн хямралаас хойших 10 жилд хамгийн өндөр түвшинд хүрлээ. Үүнд:


- MSCI индекс 24 хувиар;
- Германы DAX 25 хувиар;
- Францын CAC 25 хувиар;
- Японы Nikkei 18 хувиар;
- Хятадын CSI 300 36 хувиар тус тус өсчээ.

2019 онд даатгалын үнэлгээ 6 хувиар өссөн бөгөөд бус нутгаар дараах өсөлтийг үзүүллээ. Үүнд:

- АНУ 5 хувь;
- Их Британи 6 хувь;
- Европ тивийн улсууд 2 хувь;
- Латин Америкийн улсууд 1 хувь;
- Ази тивийн улсууд 4 хувь;
- Номхон далайн орнууд 18 хувь.

## ■ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Зураг 4. Санхүүгийн салбарын статистик үзүүлэлтүүд



### ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

- » ТОП-20 ИНДЕКС: 19,621.9 нэгж
- » MSE A: 9,531.7 нэгж
- » ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТОО: 306
- » ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИЙН ТОО: 54
- » ХАА-н гаралтай барааны арилжааны дүн: 705.1 тэрбум төгрөг
- » МИК: 78,703 зээлдэгчийн 4.1 их наяд төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

### ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

- » НИЙТ ХӨРӨНГӨ: 365.8 тэрбум төгрөг
- » НИЙТ ХУРААМЖ: 196.6 тэрбум төгрөг
- » НӨХӨН ТӨЛБӨР: 65.5 тэрбум төгрөг
- » НӨӨЦ САН: 165.6 тэрбум төгрөг
- » ГҮНЗГИЙРЭЛТ: 0.56 хувь
- » НЯГТРАЛ: 60,708 төгрөг


### БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН САЛБАР

- » ББСБ-ЫН ТОО: 538
- » НИЙТ ХӨРӨНГӨ: 1.7 их наяд төгрөг
- » НИЙТ ЗЭЭЛ: 1.2 их наяд төгрөг
- » ЗЖДХ: 3.0 хувь
- » ЗЭЭЛДЭГЧДИЙН ТОО: 419.9 мянга
- » ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН НИЙТ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ: 8.5 хувь

### ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ САЛБАР

- » ХЗХ-НЫ ТОО: 261
- » НИЙТ ХӨРӨНГӨ: 222.6 тэрбум төгрөг
- » НИЙТ ЗЭЭЛ: 156.7 тэрбум төгрөг
- » НИЙТ ХАДГАЛАМЖ: 155.8 тэрбум төгрөг
- » ЗЖДХ: 3.4 хувь, ХЖДХ: 1.6 хувь
- » ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧДИЙН ТОО: 36.4 мянга
- » ЗЭЭЛДЭГЧДИЙН ТОО: 36.3 мянга

## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



2019 онд СЗХ-ны 19 удаагийн хуралдаанаар 392 асуудлыг хэлэлцэн 441 тогтоол, СЗХ-ны даргын 610 тушаал, Ажлын албаны даргын 391 тушаал тус тус гарган хууль эрх зүйн орчин, зохицуулалтын хэрэгжилтийг хангаж ажиллав.

## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүснэгт 1. Дээд газрын тогтоол, шийдвэрийн биелэлт

№	Дээд газрын тогтоол, шийдвэрийн биелэлт	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Гүйцэтгэл
1	Монгол Улсын Засгийн газрын 2016–2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	8	90%
2	Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	64	90.3%
3	“Зээлийн хүүг бууруулах стратеги 2018–2023”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	48	90.3%
4	Чанаргүй активыг бууруулах стратегийн баримт бичиг	8	82%
5	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	3	80%
6	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэл	10	84%
7	Мөнгөний болон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх үйл ажиллагаа	20	80.7%
8	Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны “Банкны зээлийн хүүг бууруулах зах зээлийн орчныг бүрдүүлэх талаар чиглэл өгөх тухай” 07 дугаар тогтоол	5	96.1%
9	Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны “Чиглэл өгөх тухай” 10 дугаар тогтоол	7	93.6%
10	Монгол Улсын Их Хурлын даргын 2018 оны 60 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн шалгалтын санал, дүгнэлтээр өгсөн үүрэг даалгавар	12	93%
<b>НИЙТ</b>		<b>185</b>	<b>87.9%</b>

Шинээр буюу шинэчлэн найруулсан, өөрчлөлт оруулж баталсан Монгол Улсын 210 хууль, УИХ-ын 102 тогтоол, Засгийн газрын 14 тогтоолыг тус тус хүлээн авч, СЗХ-ны үйл ажиллагаанд шууд хамааралтай тогтоол шийдвэрүүдэд хяналт тавин ажиллалаа.

Санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой 10 бодлогын баримт бичгийн 185 заалтын биелэлтийг холбогдох байгууллагуудад хуулийн хугацаанд 87.9 хувийн гүйцэтгэлтэйгээр хүргүүллээ. СЗХ нь 2019 онд 7 зорилгын хүрээнд 179 ажил үйлчилгээ хийж гүйцэтгэхээр төлөвлөн 89 хувиар биелүүлж ажилласан.

**Архив, албан хэрэг хөтлөлт:** СЗХ-ны албан хэрэг хөтлөлт, архивын ажлыг “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, “Баримт бичгийн улсын стандарт”, “Байгууллагын архивын үндсэн заавар”-ын дагуу хөтлөн тайлант хугацаанд нийт 17,903 бичгийн эргэлттэй байснаас ирсэн албан бичиг 13,031, гадагш явуулсан албан бичиг 4,440, зохицуулалтын салбарын үйл ажиллагаатай холбоотой иргэд, хуулийн этгээдийн 432 өргөдлийг бүртгэж шийдвэрлэлээ. Архивын ерөнхий газар, Төрийн албаны зөвлөлтэй хамтарсан 4 жил тутамд зохион байгуулдаг “Улсын үзлэг”-т байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив албан хэрэг хөтлөлтөд мэдээллийн технологи нэвтрүүлж буй байдал зэрэг үзүүлэлтүүдээр ажлаа дүгнүүлж 90.8 буюу “А” үнэлгээ авч ажиллалаа.



## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

СЗХ–ноос баталсан нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актуудыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлж шинэчлэн боловсруулж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэх ажлын хүрээнд 2019 оны 12 дугаар сарын 31–ний өдрийн байдлаар СЗХ–ноос баталж хэм хэмжээ тогтоосон нийт 30 захиргааны хэм хэмжээний актуудыг шинээр болон шинэчлэн баталж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, бүртгүүлсэн. Үүнээс 2019 онд дараах 15 захиргааны хэм хэмжээний актыг батлан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулан бүртгүүлсэн.

Хүснэгт 2. 2019 онд бүртгэгдсэн захиргааны хэм, хэмжээний актууд

№	Тогтоол, тушаалын нэр, дугаар	ХЗДХЯ–нд бүртгэгдсэн огноо	Захиргааны хэм, хэмжээний актын нэр
1	СЗХ–ны 2016.10.18–ны өдрийн 271 дүгээр тогтоол	2019.01.02–ны өдрийн 4120 дугаарт бүртгэсэн	Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай
2	СЗХ–ны 2017.01.13–ны өдрийн 27 дугаар тогтоол	2019.01.02–ны өдрийн 4121 дугаарт бүртгэсэн	Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх тухай
3	СЗХ–ны 2018.12.26–ны өдрийн 382 дугаар тогтоол	2019.01.03–ны өдрийн 4128 дугаарт бүртгэсэн	Үнэт цаас барьцаалах тухай журам
4	СЗХ–ны 2019.01.09–ний өдрийн 04 дүгээр тогтоол	2019.01.28–ны өдрийн 4184 дугаарт бүртгэсэн	Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм
5	СЗХ–ны дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019.01.21–ний өдрийн 30/А/14 дугаартай хамтарсан тушаал	2019.01.31–ний өдрийн 4188 дугаарт бүртгэсэн	Жолоочийн даатгалын сангаас болон даатгагчаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийн мэдээллийг цагдаагийн байгууллагад ирүүлэх, түүнийг ашиглах журам
6	СЗХ–ны дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019.01.21–ний өдрийн 29/А/13 дугаартай хамтарсан тушаал	2019.01.31–ний өдрийн 4189 дугаарт бүртгэсэн	Жолоочийн даатгалын баталгааны загвар, түүнийг хэрэглэх журам
7	СЗХ–ны 2019.01.09–ний өдрийн 02 дугаар тогтоол	2019.02.04–ний өдрийн 4220 дугаарт бүртгэсэн	Даатгалын багц дүрэм
8	СЗХ–ны 2019.03.20–ны өдрийн 38 дугаар тогтоол	2019.03.28–ны өдрийн 4284 дугаарт бүртгэсэн	Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны журам
9	СЗХ–ны 2019.03.20–ны өдрийн 46 дугаар тогтоол	2019.04.03–ны өдрийн 4331 дугаарт бүртгэсэн	Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам
10	СЗХ–ны 2019.04.10–ны өдрийн 51 дүгээр тогтоол	2019.04.19–ний өдрийн 4350 дугаарт бүртгэсэн	Үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний журам
11	СЗХ–ны 2019.04.24–ний өдрийн 72 дугаар тогтоол	2019.05.02–ны өдрийн 4364 дугаарт бүртгэсэн	Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам
12	СЗХ–ны 2019 оны 211 дүгээр тогтоол	2019.07.17–ны өдрийн 4431 дугаарт бүртгэсэн	Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам
13	СЗХ–ны 2019.07.08–ны өдрийн 210 дугаар тогтоол	2019.07.22–ны өдрийн 4437 дугаарт бүртгэсэн	Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам
14	СЗХ–ны 2019.12.04–ний өдрийн 354 дүгээр тогтоол	2019.12.17–ны өдрийн 4555 дугаарт бүртгэсэн	Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай
15	СЗХ–ны 2019 оны 370 дугаар тогтоол	2019.12.27–ны өдрийн 4586 дугаарт бүртгэсэн	Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам

## ■ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2019 онд СЗХ санхүүгийн үйлчилгээг зохицуулах чиг үүргийн хүрээнд салбарын эрх зүйн орчинг бүрдүүлэх, боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар дараах арга хэмжээг авч ажилласан. Үүнд:

**Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар:** Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, танилцуулга, хуулийн төслийн үзэл баримтлал, хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналуудын хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлаад байна. Энэ хугацаанд Европын сэргээн босголт, хөгжлийн банк (EBRD)-ны Сангийн Яаман дээр хэрэгжүүлсэн хууль, эрх зүйн орчны шинэчлэл төслийн зөвлөх үнэт цаасны зах зээлийн тухай хуульд зайлшгүй тусгах шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг гаргасан. Үүнтэй холбоотойгоор хуулийн төслийг дахин өөрчлөн боловсруулах шаардлага үүсэж мэргэшсэн зөвлөхүүд ажиллуулах болсон.



Үнэт цаасны зах зээлийн тухай болон холбогдох хуулиудын давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр судалгаа хийлгүүлэхээр Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-тэй хамтран судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг судалгааны ажлыг хийж гүйцэтгэхтэй холбогдуулан үнэт цаасны салбарын хууль тогтоомжийн талаарх танилцуулга, мэдээлэл өгөх сургалтыг Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ийн ажилтнуудад зохион байгуулсан.



Хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо нэмэгдэх, төрийн байгууллагын зарим чиг үүргийг өөрийгөө зохицуулах байгууллагад шилжүүлснээр төрийн байгууллага болон мэргэжлийн холбоо хоорондын чиг үүргийн давхардлыг арилгаж, үнэт цаас гаргах, бүртгэх ажиллагаа түргэн шуурхай, хялбар болж, урт хугацаат хөрөнгө оруулалт нэмэгдэх, түүгээр дамжуулж хувийн хэвшил бизнесээ өргөтгөх, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар урт хугацаанд хэрэгжүүлэх боломжтой дэд бүтцийн бүтээн байгуулалт хийх, эргээд эдийн засгийн өсөлтийг урт хугацаанд хадгалах зэрэг чухал ач холбогдолтой. Мөн хууль, эрх зүйн зохицуулалтын орчин сайжирснаар дотоод болон гадаадын хөрөнгө оруулагч нарын оролцоо нэмэгдэх, улмаар гадаадын шууд хөрөнгө оруулалт, санхүүгийн зах зээл дээрх мөнгөн урсгал нэмэгдэх зэрэг эдийн засагт маш олон талын эерэг чухал өөрчлөлтүүд бий болно.



## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар:** Хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт, хэрэгцээ, шаардлагын урьдчилсан судалгаа, нэмэлт, өөрчлөлт оруулахад холбогдон гарах зардлын тооцоо, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн үр нөлөөний үнэлгээг тус тус "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-тай хамтран хийж гүйцэтгэсэн.



**Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар:** Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай хэд хэдэн гол асуудлууд болох хөрөнгө оруулалтын сангийн хэлбэрийг тодорхой болгох буюу нэгж эрх, хувьцааны аль нь болохыг тодорхойлох, хөрөнгө оруулалтын сангийн удирдлага зохицуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх этгээдийн эрх, үүргийг нарийвчлан тусгах, ХОС-гийн хугацааг оновчтой тогтоох, хөрөнгө оруулах хэрэгслүүдийн нэр төрлийг нэмэгдүүлэх, татварын дэмжлэг бий болгох талаар гадаад орнуудын хууль тогтоомжид үндэслэн судалсан.

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар нэгж эрх, хувьцаа гэсэн зөрүүтэй ойлголтыг тодорхой болгох, хамтын хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулж болох активын төрөлд улс орнуудын Засгийн газрын үнэт цаасыг нэмж оруулах, хөрөнгө оруулалтын сангийн удирдлага зохицуулалтын чиг үүрэгтэй холбоотой зохицуулалтууд боловсронгуй болох ач холбогдолтой юм.



## ■ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Даатгалын зах зээл:** Даатгалын салбарын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд Сангийн Яамтай хамтран Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль болон Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулаад байна. Дээрх хуулиудын шинэчилсэн найруулга, нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалын төсөлд анхдагч даатгагч нь

дотоодын давхар даатгалын компанид эрсдэлийн тодорхой хувийг даатгуулах шаардлагыг тусгах, даатгалын гэрээг цахим хэлбэрээр байгуулах, нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах үйл явцыг хялбаршуулах, цахимжуулах боломжийг хууль, эрх зүйн хувьд нээх, олон улсын жишигт нийцүүлэн даатгалын ангиллыг амьдралын болон амьдралын бус болгон өөрчилж, ялгааг нарийвчлан тусгах зэрэг олон асуудлуудыг тусгаж буйгаараа шинэлэг юм.



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын тухай хуулийн төслийг боловсруулж буйтай холбоотой холбогдох ажлын хэсэгт СЗХ-ноос төлөөлөл орж ажиллаж байна. Хууль батлагдсанаар өндөр орлоготой даатгуулагч хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд сайн дурын үндсэн дээр даатгуулах, тэдгээр даатгуулагчид тэтгэвэр тогтоолгох насанд хүрэх үеэс олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөл бүрдэнэ.

Даатгалын тухай болон холбогдох хуулиудын давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-тэй хамтран судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан 21 журам, заавар, аргачлалаас бүрдэх “Даатгалын багц дүрэм”, мөн бусад холбогдох 44 журам, зааврын хүрээнд даатгалын үйл ажиллагааг зохицуулж, хяналт тавьж байна.

## ■ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА




Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлал, холбогдох судалгаануудыг боловсруулж, холбогдох зохицуулалтын байгууллагуудаас саналыг авсан. Энэхүү шинэчилсэн хуулийн төслийг баталснаар зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, санхүүгийн үйлчилгээний шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэхэд таатай, эрсдэлийг бууруулсан орчныг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэл багатай хүргэх зохицуулалт бий болгох, хяналт шалгалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх юм.



"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ыг шинэчлэн баталсан ба банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийг урьдчилан тооцох, үнэлэх зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоосноор эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжрууллаа.

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам"-ын төслийг боловсруулж, олон нийтээс санал авч батлав. Энэхүү журмаар ББСБ-ын үйл ажиллагаа, санхүүгийн байдалд хяналт шалгалт хийж, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан журмын хэрэгжилт, ББСБ-ын санхүү, төлбөрийн чадвар, үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийн түвшинг тодорхойлон үнэлгээ, дүгнэлт өгч, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээ авахад оршино.



"Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоох, үе шаттай нэмэгдүүлэх хуваарь батлах тухай" тогтоолын төслийг боловсруулж, иргэд олон нийтээс санал авч баталсан ба банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, ББСБ-ууд үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх нөлөөтэй юм.



## ■ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, дундын санхүүгийн байгууллага, тогтворжилтын сан, хадгаламж хамгаалал зэрэг хамгаалалтын давхаргуудыг бүрдүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог сайжруулах зохицуулалтуудыг тусгаад байна. Гурван давхарга бүхий хамгаалалтын тогтолцоог бүрдүүлснээр үйл ажиллагааны түр хугацааны хүндрэлд орсон, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар алдагдсан хоршоодод мэргэжил арга зүйн болон санхүүгийн туслалцааг үзүүлэх замаар зах зээлийн найдвартай байдал, хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг хамгаалах бусад орнуудын сайн туршлага, олон улсын чиг хандлагад нийцүүлэхээр ажиллалаа. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад АХБ-ны төслийн зөвлөхүүд дэмжлэг үзүүлж, холбогдох судалгаа, санал зөвлөмжийг өгч хамтран ажиллаж байна.

Хадгаламж, зээлийн хоршооны эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэхээр бэлтгэж, эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу нийт хоршоодыг зайнаас үнэлж, 35 ХЗХ-г газар дээрх шалгалтад хамруулж зайны хяналтын үнэлгээг бодит байдалд нийцэх эсэхийг турших ажлыг гүйцэтгэсэн. Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан эрсдэлийн ангилал тус бүрээр хоршоодод авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хадгаламж, зээлийн хоршооны эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхээр хоршооны бүтэц дэх дотоод хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэгч хяналтын зөвлөлд чиглэсэн багц арга хэмжээг авсан. Энэ хүрээнд хяналтын зөвлөлийн гишүүдэд зориулсан сургалт, дотоод хяналтыг хэрэгжүүлэхэд ашиглах шалгах хуудсыг танилцуулж үйл ажиллагаанд нэвтрүүлж эхэлсэн.

## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд: “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр 2016–2021”-ийг Монголбанк, Сангийн Яам, БСШУСЯ-тай хамтран хэрэгжүүлж, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкны “Олон нийтийн боловсролын төв”, БСШУСЯ-ны харьяа “Насан туршийн боловсролын үндэсний төв”, “Бичил санхүүгийн хөгжлийн төв” зэрэг байгууллагуудын 2019.01.30-ны өдөр баталсан “Санхүүгийн боловсрол түгээх сургагч багш бэлтгэх” сургалт зохион байгуулах хамтарсан удирдамжийн дагуу Төв, Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр, Өвөрхангай, Архангай, Завхан, Хөвсгөл аймгуудад болон нийслэл Улаанбаатар хотод нийт 220 сургагч багшийг бэлтгэлээ.

Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд СЗХ-ны ажилтнуудад ажил үүргээ гүйцэтгэхэд нэн тэргүүнд шаардагдаж буй чадвар, мэдлэг олгох, СЗХ-ны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор зохион байгуулсан “Ахисан түвшний санхүүгийн дүн шинжилгээ” сургалтад СЗХ-ны 50 албан хаагч, “Эрсдэлд суурилсан хөрөнгийг тооцох сэдэвт семинар”-т СЗХ-ны албан хаагчид болон зохицуулалтын байгууллагын 70 ажилтан, “Даатгалын компаниудад эрсдэлд суурилсан хөрөнгийн шаардлагыг нэвтрүүлэх нь” сэдэвт 2 удаагийн дотоод сургалтад 25 албан хаагчид буюу давхардсан тоогоор нийт 145 ажилтан хамрагдсан.



Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран “Хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх-II” төслийн дагуу “Засгийн газрын бонд болон компанийн бондын зах зээл” сэдвийн хүрээнд сургалт, төслийн зээлжих зэрэглэл тогтоох байгууллагуудыг бий болгох, зохицуулалтын орчинг сайжруулах хүрээнд “Зээлжих зэрэглэл тогтоох байгууллагын хууль эрх зүйн орчин”, “Үйл ажиллагааны практик асуудал” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Төслийн зөвлөх баг компанийн бондын зах зээлийг хөгжүүлэх, биржийн бус зах зээлийн эрх зүйн

орчинг боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлэх чиглэлээр хэлэлцсэн.

Мэргэжлийн холбоодтой байгуулсан “Сургалт зохион байгуулах гэрээ”-ний дагуу Монголын хуульчдын холбоо, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд бэлтгэн нийлүүлэгч мэргэшсэн брокеруудын нэгдсэн холбоотой хамтран холбогдох сургалтуудыг зохион байгуулсан бөгөөд СЗХ-ноос сургалтын явц болон шалгалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, заавар, зөвлөмж өгч ажилласан.



## БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

МҮЦАЭХ-той хамтран үнэт цаасны зуучлалын, хөрөнгө оруулалтын чиглэлээр ажил, үйлчилгээ явуулах эрх олгох болон аттестатчлах сургалтыг 2019 оны 5 болон 10 дугаар саруудад зохион байгуулсан. Тэнцсэн 205 иргэдийн 43 нь үнэт цаасны зах зээл дээр зуучлалын ажил, үйлчилгээ явуулах эрх, 126 нь хөрөнгө оруулалтын ажил, үйлчилгээ явуулах эрх авсан бөгөөд 36 мэргэжилтний үнэт цаасны зах зээл дээр ажил, үйлчилгээ явуулах эрхийг аттестатчилсан.



“Санхүүгийн зах зээл” нээлттэй өдөрлөгийг Дархан-Уул, Орхон, Хөвсгөл аймгуудад зохион байгуулсан.



МББСБХ-той хамтран “ББСБ-уудын ажилтнуудыг чадавхжуулах” сургалтыг 3 удаа зохион байгуулж, 80 ББСБ-уудын удирдлага, МББСБХ-той хамтран сургалт зохион байгуулах гэрээний хүрээнд “Комплайнс ба ёс зүй” онлайн сургалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж 245 ББСБ-уудын албан хаагчид тус тус хамрагдсан байна. Мөн ББСБ-ын нягтлан бодогч нарт ББСБ-ын нягтлан бодох бүртгэл, анхаарах асуудлаар сургалт хийж 70 гаруй ББСБ-уудын төлөөлөл оролцсон. Эдгээр сургалтуудыг зохион байгуулснаар банк бус санхүүгийн зах зээлийн оролцогчдын хүний нөөцийг чадавхжуулж, зах зээлд мэргэжлийн ёс зүйтэй ажиллах мэдлэг, мэдээллээр хангаж байна.


АХБ-тай хамтран хэрэгжүүлж буй “Бичил санхүүгийн байгууллагыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд 2019 оны 5 дугаар сараас “Хадгаламж, зээлийн хоршооны эрсдэлийн удирдлага” сэдэвт сургалтыг бүсчилсэн байдлаар зохион байгуулж 42 ХЗХ-ны хяналтын зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захирал, нягтлан бодогч 142 оролцогчийг хамруулснаас гадна МХЗХҮХ-ны 23 сургагч багшийг сургаж, бэлтгэн салбарын оролцогчдыг чадавхжуулах арга хэмжээ авсан.

МХЗХҮХ-той хамтран хоршооны тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн болон гүйцэтгэх захиралд зориулсан 13 удаагийн сертификат олгох сургалтыг зохион байгуулсан бөгөөд сургалтын хөтөлбөрт мэргэжлийн ёс зүй, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, комплайнсын хэрэгжилт зэрэг сэдвээр мэдлэг олгон, мэдээлэл өгч ажилласан.

Монголын даатгалын холбоо, Монголын банкны холбоотой хамтран ажиллах гэрээний хүрээнд Улаанбаатар хотод даатгалын төлөөлөгчийн сургалтыг 3 удаа, орон нутгийн 18 аймагт тус бүр нэг удаа, мөн даатгалын зуучлагчийн сургалтыг Улаанбаатар хотод 4, орон нутагт 1, даатгалын хохирол үнэлэгчийн сургалтыг Улаанбаатар хотод 1 удаа тус тус зохион байгуулж, нийт 1152 оролцогч хамрагдлаа.



“Финтек Фронтинер Форум”-ыг зохион байгуулав.



## БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Үнэт цаасны чиглэлээр** 2019 онд дараах бүртгэл, зөвшөөрлийг олгосон. Үүнд:

- Үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл 2;
- Үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл 3;
- Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл 2;
- Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийн бүртгэл 4;
- Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн бүртгэл 3;
- Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийн бүртгэл 7;
- Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл 1;
- Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл 1;
- Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл 3;
- Номинал дансаар дамжуулан харилцагчдад брокерийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл 4;
- Хамтын хөрөнгө оруулалтын сангийн баримт бичгийн бүртгэл 1 зэрэг болно.

Зураг 5. Үнэт цаасны салбарын бүртгэл, зөвшөөрлийн мэдээлэл



Даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг 121 хүнд олгосон.



Даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрлийг 5 хуулийн этгээдэд олгосон.

Даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрлийг 2 хуулийн этгээдэд олгосон.

**Даатгалын чиглэлээр** 2019 онд дараах бүртгэл, зөвшөөрлийг олгосон. Үүнд:

- Даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл 5;
- Даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрөл 2;
- Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогч компанийн салбар нээх тусгай зөвшөөрөл 29;
- Даатгалын мэргэжлийн оролцогч компанийн тусгай зөвшөөрөл 15;
- Даатгалын бүтээгдэхүүний бүртгэл 12;
- Төлөөлөгчийн газар нээх бүртгэл 21;
- Даатгалын актуарчийн эрх болон бүртгэл 8;
- Даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл 121;
- Даатгалын байгууллагад аудит хийх эрх 1;
- Даатгалын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцийн өөрчлөлтийн зөвшөөрөл 7;
- Даатгалын компанийн оноосон нэрийн өөрчлөлт 4 зэрэг болно.

## БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зураг 6. Банк бус санхүүгийн байгууллагын салбарын бүртгэл, зөвшөөрлийн мэдээлэл



Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нийт 10 компанид шинээр олгож, 9 ББСБ–ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон, 10 ББСБ–ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэн, 8 ББСБ–ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээж, дараах зөвшөөрөл эрхүүдийг бүртгэсэн байна.

Нийт 17 ХЗХ–нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох, 52 ХЗХ–ны тусгай зөвшөөрлийг сунгах, 10 ХЗХ–ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, 1 ХЗХ–ны тусгай зөвшөөрлийг сэргээх, 35 ХЗХ–ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэсэн бол 1 ХЗХ–нд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, 27 ХЗХ–нд салбар нээх зөвшөөрөл олгон 13 ХЗХ–ны хаяг, байршлын өөрчлөлт, 34 ХЗХ–ны гүйцэтгэх захирал, сонгуульт гишүүдийн өөрчлөлтийг бүртгэжээ.

Хүснэгт 3. Банк бус санхүүгийн байгууллагын салбарын бүртгэл, зөвшөөрлийн мэдээлэл, зөвшөөрлийн төрлөөр

№	Зөвшөөрөл эрхийн нэр	Тоо
1	Оноосон нэр өөрчлөх	13
2	Нэмэлт тусгай зөвшөөрөл олгох	15
3	Салбарын зөвшөөрөл олгох	34
4	Салбар хаах	2
5	Төлөөлөгчийн газар ажлуулах зөвшөөрөл олгох	2
6	Хаяг, байршлыг өөрчлөх	59
7	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах	367
8	Гүйцэтгэх захирлыг өөрчлөх	75





## ■ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зайнаас тавих хяналт, шалгалтын хүрээнд: Зохицуулалтын байгууллагуудаас ирүүлсэн сар, улирлын санхүүгийн тайлан тэнцэл болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлангуудыг хүлээн авч хянан, зөрчил, дутагдлыг арилгах талаар тайлангийн хариугаар хугацаатай үүрэг, даалгавар өгч биелэлтэд хяналт тавьж ажиллалаа. Давхардсан тоогоор сарын болон улирлын нийт 10,573 санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан, мэдээнд зайны хяналтыг хийж гүйцэтгэлээ.

Үнэт цаасны хяналтын чиглэлээр 139 ХК, 47 ҮЦК, 10 ХОМК, 3 кастодианы үйл ажиллагаа эрхлэгчийн 2018 оны жилийн санхүүгийн тайлан, мэдээ, 99 ХК-ийн 2019 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлан, мэдээг тус тус ФинА системээр хүлээн авч хянасан.

Даатгалын хяналтын чиглэлээр 89 даатгалын байгууллагын 2018 оны жилийн эцсийн, 91 байгууллагын 2019 оны 1 дүгээр улирлын, 90 байгууллагын 2 дугаар улирлын, 89 байгууллагын 3

дугаар улирлын санхүүгийн тайланг тус тус хүлээн авч хянан, ФинА системд баталгаажуулсан бол “Албан журмын даатгагчдын холбоо” ТББ-ын 2018 оны 4, 2019 оны 1–4 дүгээр улирлын санхүүгийн тайлангуудыг мөн хүлээн авч хянан, системд баталгаажуулсан.

Банк бус санхүүгийн байгууллагын хяналтын чиглэлээр 2019 онд давхардсан тоогоор 2,155 ББСБ-ын тайлан, мэдээг хүлээн авч хянан, баталгаажуулан ажиллалаа. Түүнчлэн 2018 оны 12 дугаар сар, 2019 оны 1–11 дүгээр сарын 6,649 мэдээг хүлээн авч хянан, ФинА системд баталгаажуулсан.

Хадгаламж, зээлийн хоршооны хяналтын чиглэлээр 279 ХЗХ-ны 2018 оны 4 дүгээр улирлын, 282 ХЗХ-ны 2019 оны 1 дүгээр улирлын, 275 ХЗХ-ны 2 дугаар улирлын, 261 ХЗХ-ны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан тэнцэл, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан, мэдээг хүлээн авч хянан ФинА системд баталгаажуулсан.

Зураг 7. Зайны хяналт, шалгалтын мэдээлэл /давхардсан тоогоор/



Үнэт цаасны арилжааны хяналтын тогтолцоог сайжруулах, үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл болон хурлын материалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянаж, нэгдсэн дүгнэлт гаргах чиглэлийн хүрээнд:

Нийт 155 ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг хянаж, хурлаа хуралдуулсан 135 ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг хянан, холбогдох хариуг хүргүүлсэн. Нэр бүхий 53 ХК хувьцаа эзэмшигчдийн хурлаа

хуралдуулаагүйг СЗХ-ны цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн.

103 ХК ногдол ашиг тараах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг СЗХ-нд ирүүлснээс 26 нь нийт 62.2 тэрбум төгрөгийн ногдол ашгийг 61,091 хувьцаа эзэмшигчид олгохоор шийдвэрлэсэн байна.


## ■ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Газар дээрх хяналт, шалгалтын хүрээнд:** 2019 онд үнэт цаасны зах зээлийн оролцогч байгууллагууд, хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжаалсан компаниуд, даатгалын салбарын мэргэжлийн оролцогчид, банк бус санхүүгийн байгууллагууд, хадгаламж, зээлийн хоршоод болон үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын нийт 1,022 байгууллага (салбарын тоо болон санхүүгийн нэгдэлд оролцогчдыг оруулан тооцоноор)–ын үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалтыг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар хийж гүйцэтгэлээ.

2019 онд хийж гүйцэтгэвэл зохих газар дээрх хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу 68 ББСБ, 17 ХОМК, “Арилжааны төлбөр тооцоо” ХХК, “Монголын үнэт цаасны бирж” ХК, нэр бүхий 10 ХК, Засгийн газрын 100 хувийн санхүүжилттэй Зээлийн батлан даалтын сан, 5 даатгалын компани, “Албан журмын даатгагчдын холбоо” ТББ–ын үйл ажиллагаанд иж бүрэн шалгалт, 9 даатгалын зуучлагч компанийн үйл ажиллагаанд хэсэгчилсэн хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Мөн 6 ХЗХ–нд газар дээрх иж бүрэн, 32 ХЗХ–нд хэсэгчилсэн үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

МУТСТ чиглэлээр эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу нийт 113, үүнээс 17 ҮЦК, 7 даатгалын компани, 3 даатгалын хохирол үнэлэгч, 19 даатгалын зуучлагч, 13 ХЗХ, 20 ББСБ, 34 үл хөдлөх хөрөнгийн зуучлагчийн үйл ажиллагаанд иж бүрэн хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Зорилтот хяналт, шалгалтын чиглэлээр цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 29 ББСБ–д газар дээрх хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн бол үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн

Зураг 8. МУТСТ чиглэлээр гүйцэтгэсэн газар дээрх хяналт, шалгалт



үйл ажиллагааны чиглэлээр 5 газар дээрх хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Мөн СЗХ–ноос өмнө нь өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг биечлэн шалгах зорилгоор 12 байгууллагад газар дээрх үзлэгийг 2019 оны 4 дүгээр улиралд хийж гүйцэтгэв.

Монголбанктай хамтран Монголбанк, СЗХ–ны хяналт, зохицуулалтын хүрээний байгууллага, санхүүгийн нэгдэлд хамаарах 37 толгой компани, 9 банк, 39 ББСБ, 11 даатгалын байгууллага, 16 ҮЦК, 4 ХЗХ болон бусад 325 компани, нийт 404 компани /37 толгой компани орсноор/–уудад шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Мөн төлөвлөгөөт бус хяналт, шалгалтын хүрээнд “Монголын хөрөнгийн бирж” ХК, “УИД” ХК–д газар дээрх хяналт, шалгалт, 22 ББСБ–д хэсэгчилсэн хяналт, шалгалт, давхардсан тоогоор 3 даатгалын компани, орон нутаг дахь нийт 17 байгууллагын 126 салбар, төлөөлөгчийн газарт үзлэг, олон нийтэд хувьцаагаа санал болгосон нэр бүхий 9 ХК–д тус тус хяналт, шалгалтыг хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажилласан.

Зураг 9. Газар дээрх хяналт, шалгалтын мэдээлэл, салбарын оролцогчдоор



## ■ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

УБАШ–ын биелэлт, захиргааны хариуцлага ногдуулалтын биелэлтийг хангуулах талаар хяналт тавьж ажиллах хүрээнд 2019 онд 5 чиглэлээс нийт 89 УБАШ хүргүүлснээс үнэт цаасны хяналтын чиглэлээр 7, ББСБ–ын хяналтын чиглэлээр 23, ХЗХ–ны хяналтын чиглэлээр 11, даатгалын хяналтын чиглэлээр 20, МУТСТ хяналтын чиглэлээр 28 УБАШ–ыг тус тус хүргүүлэн, шаардлагыг хангуулан ажиллаж байна.

Үйл ажиллагаа нь доголдсон, холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй зохицуулалтын байгууллагуудын тусгай зөвшөөрлийг

түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох хүрээнд СЗХ–ны хуралдаанаар 132 асуудал буюу тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн 42, тусгай зөвшөөрлийг сэргээсэн 16, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон 70, ҮЦК–ийн харилцагчийг шилжүүлсэн 3, компанийн хэлбэр өөрчилсөн 1 асуудлыг тус тус хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.

Улсын тэмдэгтийн хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлс, торгууль шийтгэврийн төлөлтөд хяналт тавих ажлын хүрээнд 2019 онд нийт 213.7 сая төгрөгийн торгууль шийтгэлийг төлүүлээд байна.

Зураг 10. Улсын байцаагчийн албан шаардлагын мэдээлэл



СЗХ нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлд мөн хяналт тавин ажилладаг бөгөөд тайлант онд тус чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Нэр бүхий 16 даатгалын байгууллагын үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэсэн.
- Нэр бүхий ХХК нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийг зөрчсөн тул зөрчлийн хэрэг, бүртгэл нээн ажилласнаар торгуулийн арга хэмжээ авч ажилласан.
- Нэр бүхий 45 хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр олон улсын шуудан, илгээмжийн үйлчилгээний үнэ тарифыг Монгол улсын нутаг дэвсгэрт хэрхэн

илэрхийлэх, 2018 оны 11 дүгээр сард хийсэн газар дээрх хяналт, шалгалтаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах арга замын талаар зөвлөмж хүргүүлсэн.

- Нэр бүхий 38 ХЗХ–нд хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл хүргүүлж ажилласан.
- Хуулийг зөрчсөн нэр бүхий компаниуд гадаад валютаар ажил, гүйлгээ хийсэн учир зөрчлийн хэрэг нээн нэр бүхий 1 ХХК, 1 ХК–д тус бүр 40.0 сая төгрөгийн торгууль ногдуулсан.
- Мөнгө угаах, терроризмтэй тэмцэх тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн ханган ажиллах талаар сургалт зохион байгуулж, заавар, зөвлөмж өгч ажилласан.

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тусгай зөвшөөрөл эзэмшигч, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хүрээнд нийт 346 өргөдөл, гомдол ирснээс 333 нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн бол нийт 600 гаруй иргэнд мэргэжлийн зөвлөгөө, тодруулга, мэдээллийг утсаар болон биечлэн уулзаж өгсөн.

Тайлант онд 14 иргэний өргөдлийг харьяаллын дагуу цагдаагийн байгууллагад шилжүүлсэн ба нийт 18 иргэний хохирлыг барагдуулахаар нэр бүхий 3

ҮЦК-д үүрэг даалгавар өгч, 5 иргэний Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж дахь дансанд нэр бүхий 5 ХК-ийн нийт 8,490 ширхэг хувьцааг тус тус буцаан байршуулж, 2 иргэний хувьцаанд оногдох нийт 800.0 мянган төгрөгийн хохирлыг бүрэн барагдуулсан.

Даатгуулагч нийт 70 этгээдийн нөхөн төлбөрт нийт 855.2 сая төгрөгийг олгуулахаар урьдчилсан шийдвэрийг гаргаснаас нийт 34 этгээдийн 277.9 сая төгрөгийн нөхөн төлбөр төлөгдсөн.

Зураг 11. Өргөдөл, гомдол, тэдгээрийн шийдвэрлэлтийн мэдээлэл



## МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр



СЗХ–ны 2019 оны 212 дугаар тогтоолоор “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх тухай журам”–д нэмэлт өөрчлөлт оруулж ФАТФ–ын Зөвлөмж 26.6–д заасан шаардлагыг хангаж ажилласан. Үүний үр дүнд тухайн байгууллагын түвшинд томоохон хэмжээний өөрчлөлт орсон тохиолдолд мэдээлэх үүрэгтэй этгээдийн эрсдэлийн үнэлгээнд өөрчлөлт оруулах зохицуулалттай болсон. Түүнчлэн тус онд энэхүү журамд нэмэлт өөрчлөлт оруулан ФАТФ–ын зөвлөмжийн дагуу хяналт, шалгалт хийх тогтолцоог бүрдүүлсэн. Мөн СЗХ–ны хуралдаанаар салбаруудын тусгайлсан журмуудад өөрчлөлт оруулж, батлан ФАТФ–ын стандартад нийцүүлсэн.

ФАТФ–ын Зөвлөмж 26–д заасан шаардлагыг биелүүлэхтэй холбоотой тохиромжтой этгээдийн шаардлагуудыг тус бүрийн хууль, журмаар зохицуулахаар өөрчлөлт оруулав.

СЗХ–ны зохицуулалттай үйл ажиллагааг зөвшөөрөлгүй эрхэлсэн этгээдэд ногдуулах торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх саналыг боловсруулж, Зөрчлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6–д нэмэлт, өөрчлөлт оруулахаар УИХ–д хүргүүлсэн.

СЗХ–ны Ажлын албаны даргын 2019 оны 199 дүгээр тушаалаар “Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, гадаад валютын арилжааг тусгай зөвшөөрөлгүй эрхэлж буй этгээдийг олж тогтоох, хяналт тавих, мэдээлэх заавар”–ыг баталсан. Уг зааврыг баталснаар банк бус санхүүгийн байгууллагын цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээг СЗХ–ны тусгай зөвшөөрөлгүй, хууль бусаар эрхэлсэн этгээдийн мэдээлэл авах сувгийг нэмэгдүүлж, тэдгээрийг илрүүлэх, олж тогтоох, хууль тогтоомжид заасан арга хэмжээ авах, нийтэд мэдээлэх тогтолцоо бий болов.

Түүнчлэн СЗХ–ны Ажлын албаны даргын 2019 оны 200 дугаар тушаалаар “Хянан шалгагчид зориулсан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх чиглэлээр газар дээрх хяналт шалгалт хийх гарын авлага”–ыг баталсан. Үүний үр дүнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хяналт, шалгалт хийхэд хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгалтын цар хүрээ, дараалал зэрэг зохицуулалтын нарийвчилсан.






## МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



### Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлийг үнэлэх чиглэлээр

СЗХ–ноос 2018 онд ФАТФ–ын Зөвлөмж 1 буюу Эрсдэлийн үнэлгээнд заасан зөвлөмжийн дагуу Олон улсын валютын сангийн эрсдэлийг үнэлэх аргачлалыг ашиглаж үнэт цаас, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо зэрэг нийт 4 салбарын эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн.

2019 оны 11, 12 дугаар саруудад салбарын эрсдэлийн үнэлгээний үзүүлэлт болон холбогдох бусад хүчин зүйлсийн үр дүнд үндэслэн, нийт 1,033 мэдээлэх үүрэгтэй этгээдийн тус бүрийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг ОУВС–гийн аргачлалыг ашиглан үнэлж, эрсдэлийн мэдээллийн санг үүсгэв.



Хамтарсан бүлгээс Шууд хэрэгжилт 3 буюу Хяналт шалгалтын хүрээнд “Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг хянан шалгах байгууллагын тухайн салбарын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн талаарх ойлголтыг сайжруулах, хяналт, шалгалтыг эрсдэлд суурилсан аргачлалаар хийж гүйцэтгэх, МУТСТ үүргээ зөрчсөн тохиолдолд гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн арга хэмжээ авах” үүрэг даалгаврыг өгсөн.

Үүнтэй холбоотойгоор 2019 онд СЗХ–ноос зохицуулалтын буюу үнэт цаас, даатгал, банк бус санхүүгийн, хадгаламж зээлийн хоршооны салбарууд болон шинээр нэмэгдсэн санхүүгийн бус секторууд болох үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын, үнэт металл, үнэт чулууны салбарууд болох нийт 6 салбарт мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх салбарын эрсдэлийн үнэлгээг “Эм Эм Си Жи” ХХК судалгааны байгууллагатай хамтран гүйцэтгэсэн.



## МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Урьдчилан сэргийлэх арга хэмжээний чиглэлээр



СЗХ–ноос “Комплаинс ба Ёс зүй” онлайн сургалтыг Банк санхүүгийн академи, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоотой хамтран зохион байгуулж, 2019 оны 6 дугаар сараас 300 гаруй банк бус санхүүгийн байгууллагуудыг уг сургалтад хамруулж, сертификат олгов. Танхимын сургалтыг СЗХ дангаар болон мэргэжлийн холбоодтой хамтран Улаанбаатар болон орон нутагт нийт 27 удаа зохион байгуулж, 1,000 гаруй оролцогчдыг хамруулан ажиллав.



СЗХ–ны зохицуулалттай мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулан “Банкнаас бусад санхүүгийн байгууллагын комплаинсын ажилтанд зориулсан гарын авлага”–ыг мэргэжлийн холбоодтой хамтран боловсруулав. Уг гарын авлагыг мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал хариуцсан буюу комплаинсын ажилтнуудад зориулж практик зэвлэмж өгөхөд чиглэж бэлтгэсэн бөгөөд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл, үүнтэй холбоотой дагаж мөрдөх, биелүүлэх шаардлагууд төдийгүй бизнесийн ёс зүй, шүгэл үлээх, нууцлалыг хамгаалах зэрэг өртөн цар хүрээг хамарсан асуудлуудыг тусгасан.

“Санхүүгийн салбарын комплаинс форум – 2019”–ийг СЗХ–ноос хоёр дахь удаагаа 2019 оны 6 дугаар сарын 18–ны өдөр Азийн сангийн санхүүжилтээр зохион байгуулж, Дэлхийн банк, ОУВС зэрэг олон улсын байгууллагууд, мэдээлэх үүрэгтэй этгээдийн төлөөллийг хамруулж зохион байгуулсан бөгөөд тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга зам зэрэг сэдвийг хамарсан хэлэлцүүлэг хийв.



Санхүүгийн салбарын мэргэжлийн холбоодуудтай МУТС–тэй тэмцэх чиглэлээр сургалт зохион байгуулах, хамтран ажиллах гэрээг 2019 оны 12 дугаар сарын 23–ны өдөр байгуулав.



## МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ хэрэгжүүлэх байгууллага (ФАТФ)-д хүргүүлсэн тайлан**


2019 онд СЗХ мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлд хэрэгжүүлж буй арга хэмжээний тайланг ФАТФ-д “Техникийн зөвлөмжийг биелүүлэх чиглэл”, “Үр дүнтэй байдлын шууд хэрэгжилтийг хангуулах чиглэл”-ийн дагуу тухай бүр боловсруулан хүргүүлж, тогтоосон хугацаанд танилцуулан, хамгаалсан.

Техникийн зөвлөмжийг биелүүлэх чиглэлээр: Монгол Улсын 2017 оны Харилцан үнэлгээний тайланд тусгагдсан 20 техникийн зөвлөмжийн үнэлгээг ахиулах зорилгоор Дахин үнэлгээний тайланг Монгол Улсаас Ази Номхон далайн бүсийн бүлэгт хүсэлт хүргүүлж, 2019 оны 01 дүгээр сард тайлан, тайлбар тодруулгуудыг хүргүүлэв. Тайлангийн хамгаалалтыг 2019 оны 8 дугаар сард Австрали улсын Канберра хотод АНДББ-ийн 22 дахь жилийн уулзалтаар хийж, СЗХ-ноос холбогдох зөвлөмжийн үнэлгээг сайжруулах зорилгоор танилцуулсан. 2019 оны 10 дугаар сард ФАТФ-аас Монгол Улсын Дахин үнэлгээний тайланг нийтэлсэн. СЗХ-нд хамаарах 12 үзүүлэлтийн үнэлгээ байснаас 8 үзүүлэлтийн үнэлгээг 1 шатаар, 4 үнэлгээг 2 шатаар ахиулж ажилласан.

Нийт 20 зөвлөмжийн үнэлгээг ахиулахаас 16 зөвлөмжийн үнэлгээг ахиулж, зөвлөмж 1, 8, 14, 35-ын үнэлгээг өөрчлөөгүй болно.

Үр дүнтэй байдлын Шууд хэрэгжилтийг хангуулах чиглэлээр: 2019 оны 7 дугаар сарын 22-ны өдөр Үр дүнтэй байдлын Шууд хэрэгжилтийн тайланг хүргүүлж, 9 дүгээр сарын 01-ний өдөр нэмэлт тодруулгуудыг бэлтгэж нэгдсэн байдлаар хүргүүлсэн. СЗХ нь 9 дүгээр сарын 09-нөөс 13-ны өдрүүдэд Тайланд улсын Бангкок хотод Шууд хэрэгжилт 4 буюу Урьдчилан сэргийлэх арга хэмжээг амжилттай хамгаалав.

Монгол Улсыг ФАТФ 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит хурлаараа стратегийн дутагдалтай орнуудын нэгд буюу саарал жагсаалтад оруулж 4 Үр дүнтэй байдлын Шууд хэрэгжилтийн хүрээнд 6 хугацаатай үүрэг даалгаврыг өгсөн. Хамтарсан бүлэгт хүргүүлэх эхний явцын тайланг өгсөн үүрэг даалгаврын хүрээнд, батлагдсан төлөвлөгөөний дагуу холбогдох мэдээллийг тусгаж, тайлагнан 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлэв.



## МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

СЗХ-ны зохицуулалтад үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид, үл хөдлөх эд хөрөнгө зуучлагчид шинээр нэмэгдсэнтэй холбоотой авч хэрэгжүүлсэн ажлууд

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, терроризмтой тэмцэх тухай хууль 2019 оны 10 дугаар сард батлагдаж, дагаж гарсан хуулиуд болох Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль зэрэг холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт орж, үнэт металл, үнэт чулуу, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагааг СЗХ хянаж, зохицуулах үүргийг хүлээсэн.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах зорилгоор багц хуулийн төслийг боловсруулсан. СЗХ-ны Ажлын албаны даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 391 дүгээр тушаалаар Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын болон үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, тус бүрийн салбарын зохицуулалтыг бий болгох, холбогдох журам зааврыг боловсруулж батлуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж ажиллав.

Үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч, үл хөдлөх эд хөрөнгө зуучлагч байгууллагуудыг илрүүлэх, олж тогтоох, тэдгээрийн нэгдсэн мэдээллийн сан бий болгох, бизнесийн регистрт бүртгүүлэх ажлыг хийхтэй холбоотой 2019 оны 12 дугаар сард СЗХ, Үндэсний статистикийн хороотой хамтын ажиллагааны гэрээ байгуулж, хамтран ажиллаж байна.

СЗХ-ноос салбарын болон санхүүгийн байгууллагын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлийн түвшинг тодорхойлоод байна.

Урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүргүүлэх, сургалт зохион байгуулах ажлын хүрээнд СЗХ-ны Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны хүрээнд үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч, үл хөдлөх эд хөрөнгө зуучлагч байгууллагуудад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой анхан шатны сургалтыг Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад зохион байгуулав.




## ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол Улсын банкнаас бусад санхүүгийн салбарын хөгжлийг олон улсын түвшинд хүргэх, бүс нутгийн санхүүгийн интеграцид нэгдэх үйл явцыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд СЗХ нь гадаад орны санхүүгийн зохицуулагч байгууллагууд, олон улсын хамтын нийгэмлэгийн байгууллагууд, мэргэжлийн холбоод болон хөгжлийн донор байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж ажиллалаа.



2016 оноос СЗХ-ны албан хаагчид Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн “Хэрэглэгчийг чадавхжуулах, зах зээлийг зохицуулах”, “Дижитал санхүүгийн үйлчилгээ”, “Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдөл”, “Санхүүгийн хүртээмжийн стратеги”, “Олон улсын стандартыг зохистой хэрэгжүүлэх”, “Жижиг, дунд үйлдвэрлэлийн санхүүжилт” зэрэг зургаан ажлын хэсэгт тогтмол ажиллаж, бодлого боловсруулах үйл явцад идэвхтэй оролцож байгаагийн зэрэгцээ 2019 онд шинээр бий болсон “Хүртээмжтэй ногоон санхүү” ажлын хэсэгт мөн гишүүнээр ажиллаж байна. Тус нийгэмлэгийн “Зүүн Европ, Төв Азийн Бүсийн Санаачилга”-ын гишүүн бөгөөд санхүүгийн хүртээмжийг бүс нутгийн хэмжээнд сайжруулах төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлж ажилласан.



СЗХ нь Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI), Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO), Олон улсын даатгалын зохицуулагчдын холбоо (IAIS), Олон улсын хадгаламж зээлийн хоршооны зохицуулагчдын сүлжээ (ICURN) зэрэг мэргэжлийн байгууллагуудад нэгдэж, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцож байна. Тухайлбал Олон улсын даатгалын зохицуулагчдын холбооны олон талт хамтын ажиллагааны санамж бичигт элсэх хүсэлтээ хүргүүллээ. Түүнчлэн, Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас хэрэгжүүлдэг хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын 38 зарчмыг СЗХ-ны үйл ажиллагаанд нийцүүлэх судалгааг хийж, тус байгууллагын “Өргөтгөсөн” олон талт хамтын ажиллагааны санамж бичигт нэгдэхээр хүсэлтээ боловсруулан ажиллаж байна.

СЗХ Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн Захирлуудын зөвлөлийн гишүүнээр 2017 оноос сонгогдон ажиллаж, 2019 онд улиран сонгогдож, дэлхийн санхүүгийн хүртээмжийг хөгжүүлэх бодлого, стратегийг боловсруулах, хэрэгжүүлэхэд идэвхтэй ажиллаж байна.



## ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

СЗХ нь банкнаас бусад санхүүгийн зах зээлийн чадавхыг сайжруулах чиглэлээр олон улсын банк, донор, олон улсын хамтын нийгэмлэгийн байгууллагуудтай техникийн туслалцааны төсөл, хөтөлбөрүүдийг хамтран үр ашигтай хэрэгжүүлж ажиллалаа.



Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ)-тай хамтран “Монгол улсын мөнгөний болон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх стратеги” техникийн хамтын ажиллагаа (ТХА)-ны төслийн хүрээнд үнэт цаасны төлбөр, тооцооны “Төлбөрийн эсрэг нийлүүлэлт” (Delivery versus Payment) зарчим, дараа төлбөрт тооцооны T+2 горимыг нэвтрүүлэх төслийг амжилттай хэрэгжүүллээ. Түүнчлэн “Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын эрх зүйн

орчныг дэмжих” төслийн хүрээнд Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах арга зүйн туслалцаа үзүүлэх төслийг тус банктай хамтран хэрэгжүүлж байна.

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай “Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх-II” төслийг 2019 онд хэрэгжүүлж, компанийн бондын зах зээлийг хөгжүүлэхийн тулд зах зээлийн орчны судалгаа хийх, бодлогын зөвлөмж боловсруулах, зэрэглэл тогтоох байгууллагын тогтолцоог судлах, биржийн бус арилжааны эрх зүйн зохицуулалт, тогтолцооны зарчмыг тодорхойлох зэрэг ажлуудыг хамтран хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд Монголын эдийн засгийн судалгааны хүрээлэн “Компанийн бондын зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал” судалгаа хийж, олон улсын зөвлөхөөр “Монголын компанийн бондын зах зээлийн хөгжлийн асуудал, шийдвэрлэх арга зам, зөвлөмж”-ийг боловсруулан ажиллав.



Азийн хөгжлийн банктай хамтран “Бичил санхүүгийн салбарыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх” төслийг 2019 оны 5 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд хадгаламж, зээлийн хоршоодыг чадавхжуулах, эрсдэл өндөртэй хоршоог нэгтгэх, нийлүүлэх боломжуудыг судлах, мөн эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг нэвтрүүлэх ажлуудыг хийж байна.

## ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА



болон санхүүгийн зах зээлийн хөгжлийн ирээдүйн чиг хандлагад нийцүүлэн “2019–2021 онд хэрэгжүүлэх дунд хугацааны сургалтын хөтөлбөр”-ийг олон улсын зөвлөлтэй хамтран бэлтгэсэн.

ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-тэй хамтран “Азийн орнуудад хүртээмжтэй даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд зохицуулалтын байгууллагын оролцоо” (RFPI Asia) хөтөлбөр, мөн Хүртээмжтэй даатгалын харилцан туршлага солилцох сүлжээ (MEFIN)-тэй хамтран төр, хувийн хэвшлийн олон улсын зөвлөлдөх ээлжит VII уулзалтыг 2019 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан.



СЗХ нь АНУ, Их Британи болон Австрали Улсаас Монгол Улсад суугаа элчин сайдын яамдтай Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах чиглэлээр, ялангуяа ФАТФ-ын стратегийн дутагдалтай улсуудын ажиглалтын “саарал” жагсаалтаас гарахад техник, арга зүйн туслалцаа авч, хамтран ажиллаж байна.




## СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ



СЗХ нь 2019 онд салбарын оролцогчид, олон нийтийг мэдээ, мэдээллээр хангах, санхүүгийн зах зээлийн талаарх олон нийтийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор “Санхүүгийн салбарын тойм”-ыг улирал бүр, “Хүртээмжтэй санхүү” сэтгүүлийг сар бүр эрхлэн гаргалаа. Мөн судалгаа, шинжилгээнд суурилан шийдвэр гаргах, бодлого боловсруулах чиглэлийг баримтлан тайлант хугацаанд санхүүгийн салбарын зохицуулалт, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, эрсдэлийн удирдлагын чиглэлээр арав гаруй судалгааны ажлыг гүйцэтгэлээ.

Салбарын тойм, сэтгүүл, тоон мэдээлэл, судалгааны ажлыг СЗХ-ны цахим хуудас ([www.frc.mn](http://www.frc.mn)), цахим шуудан ([rsa@frc.mn](mailto:rsa@frc.mn)) болон 51-261012 утсаар холбогдон авах боломжтой.



## ТӨСӨВ, САНХҮҮ


Хүснэгт 4. Төсөв, санхүүгийн мэдээлэл

Зарцуулсан төсөв	3,762.2 сая төгрөг	
Үүнээс: Улсын төсвийн санхүүжилтийн эх үүсвэрээр	2,740.2 сая төгрөг	73%
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	1,022.0 сая төгрөг	27%
<b>Зохицуулалтын үйлчилгээний орлого</b>	<b>2,331.3 сая төгрөг</b>	
Үүнээс: Банк бус санхүүгийн байгууллагын салбараас	1,005.2 сая төгрөг	43.1%
Даатгалын салбараас	654.2 сая төгрөг	28.1%
Үнэт цаасны салбараас	647.9 сая төгрөг	27.8%
Хадгаламж, зээлийн хоршоодын салбараас	24.0 сая төгрөг	1.0%

2019 онд 3,762.2 сая төгрөгийн төсөвтэйгөөр үйл ажиллагаагаа явуулж, үүний 73 хувийг улсын төсвийн санхүүжилтийн эх үүсвэрээр, 27 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу зохицуулалтын үйлчилгээний хураамжийн орлогын эх үүсвэрээр тус тус санхүүжүүлснээр СЗХ-ны үйл ажиллагааг жигд тогтмол тасралтгүй хэвийн явуулах санхүүгийн нөөцөөр хангаж ажилласан.

Тайлант хугацаанд зохицуулалтын үйлчилгээний орлого 2.3 тэрбум төгрөг төвлөрснөөс 43.1 хувь буюу 1,005.2 сая төгрөгийг ББСБ-ын салбараас, 28.1 хувь буюу 654.2 сая төгрөгийг даатгалын салбараас, 27.8 хувь буюу 647.9 сая төгрөгийг үнэт цаасны салбараас, 1.0 хувь буюу 24.0 сая төгрөгийг ХЗХ-ны салбараас тус тус бүрдүүлжээ.

Улсын төсөвт тэмдэгтийн хураамжийн орлого 64.2 сая төгрөг, торгуулийн орлого 213.7 сая төгрөгийг тус тус төвлөрүүлээ.



# ОЛОЛТ, АМЖИЛТ

САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАГЧ  
БАЙГУУЛЛАГА  
БАЙГУУЛАГДСАНЫ  
25 ЖИЛИЙН ОЙ  
ТОХИОВ.

4 ХК 42.5 ТЭРБУМ  
ТӨГРӨГИЙГ  
АНХДАГЧ ЗАХ  
ЗЭЭЛЭЭС  
АМЖИЛТТАЙ  
ТӨВЛӨРҮҮЛЭВ.

ХАДГАЛАМЖ,  
ЗЭЭЛИЙН  
ХОРШООДЫН  
ГИШҮҮДИЙН  
ТОО 70,968 БОЛЖ  
НЭМЭГДЭВ.

БАНКНААС БУСАД  
САНХҮҮГИЙН  
ЗАХ ЗЭЭЛИЙН  
ХЭМЖЭЭ ДНБ-НИЙ  
13.6 ХУВЬД ХҮРЧ  
ӨСӨВ.

ДААТГАЛЫН  
НЯГТРАЛ 60,708  
ТӨГРӨГ БОЛЖ  
ӨСӨВ.

ТЕХНОЛОГИД  
СУУРИЛСАН ЗЭЭЛ,  
ДААТГАЛЫН  
ҮЙЛЧИЛГЭЭ ЗАХ  
ЗЭЭЛД ХҮРДТАЙ  
НЭВТЭРЧ  
БАЙНА.

ББСБ-ЫН ЧАНАРГУЙ  
ЗЭЭЛИЙН НИЙТ  
ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ  
8.5, ЗЭЭЛИЙН ХҮҮ  
8.0 ХУВЬД ХҮРЧ ТУС  
ТУС БУУРАВ.

# 2019







Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia